

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Хороодын Засаг дарга нар, хэсгийн ахлагч нарын цалинг нэмэгдүүлэх санал боловсруулж танилцуулах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дүүргийн Засаг дарга нар/				
	Дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар 1-24 дүгээр хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нартай бүсчилсэн уулзалтыг 04 дүгээр сарын 12-ноос 18-ны хооронд зохион байгуулан ажиллаж байна. Уулзалтын хүрээнд гарсан санал хүсэлтэд тулгуурлан хороодын Засаг дарга нар, хэсгийн ахлагч нарын цалинг нэмэгдүүлэх санал боловсруулан хүргүүлнэ.			
Үүрэг даалгавар ХОЁР: Нийслэлийн хэмжээнд 2023 онд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгаврыг яаралтай бэлэн болгож, худалдан авах ажиллагааны эрх шилжсэн байгууллагад шуурхай хүргүүлж, ажлаа уялдуулж ажиллах. /Эрх шилжсэн байгууллага болон захиалагчийн хяналт тавьж байгаа байгууллагууд/				
	<p>ТГУХ Дүүрэг, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих дүүргийн Нийтлэг үйлчилгээний газрын хэрэгцээнд шаардлагатай машин механизм худалдан авах техникийн тодорхойлолт, “Ногоон бүс” камержуулалтын ажлын багц-1, 2, 3 дүүргийн теле хяналтын камерын төвд шаардлагатай хяналтын камер нийлүүлэх техникийн тодорхойлолт, дүүргийн теле хяналтын камерын төвд шаардлагатай хард диск нийлүүлэх техникийн тодорхойлолтыг дүүргийн Худалдан авах ажиллагааны хэлтэст хүргүүлэн ажилласан.</p> <p>ТНААХ Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 11, 13, 14, 15, 17, 23 дугаар хороодын нутаг дэвсгэрт "Гудамж сайжруулах" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр зураг, төсвийг батлуулж дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд 3/544 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн 21,23,24 дүгээр хороодын байрны ажлын даалгаврыг авахаар цахилгаан, дулаан, цахилгаан холбооны техникийн нөхцөлүүдийг хүсэлт хүргүүлэн ажиллаж байна.</p>			
Үүрэг даалгавар ГУРАВ: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, цахим хуудас мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, ажлаа эрчимжүүлэх. /Нийт байгууллагууд/				
	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр нээлттэй, ил тод, шуурхай, хүртээмжийг нэмэгдүүлэхэд зорилгоор Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадаас Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлтийн мэдээллийг нэгтгэсэн авч ажиллаж байна.			

	<p>Вэб сайтын өмнөх мэдээллүүдийн үг үсгийн алдааг засаж залруулга, ФБ хуудас болон вэб сайтын мэдээллийн стандартыг бий болголоо.</p> <p>Цахим хуудсанд нийтлэх гэрэл зургийн стандартыг бий болгож, утга найруулгын алдаагүй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэхээр мэдээ бүрийг хянан ажиллаж байна.</p> <p>Дүүргийн цахим хуудасны өнгө үзэмжийг сайжруулах коверыг солих ажлыг хийж гүйцэтгэлээ.</p>			
<p>Үүрэг даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн хэмжээнд орон сууцны зориулалтай барилгын 1 давхрыг өргөтгөөд үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын барилга, байгууламжид газар хөдлөлт холбоотой эрсдэлийн үнэлгээ хийлгүүлж, арга зүйгээр хангах, газар хөдлөлтийг тэсвэрлэх чадавхын үнэлгээ, эрсдэл, нөхцөл байдлын талаар дараагийн Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах. /Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Онцгой байдлын газар, Хотын стандарт хяналтын газар, Хот байгуулалт хөгжлийн газар, Дүүргүүдийн Засаг дарга нар/</p>				
	<p>ОБХ</p> <p>Дүүргийн хэмжээнд орон сууцны барилгын 1 давхрыг өргөтгөн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг гаргаж Нийслэлийн Онцгой байдлын газарт 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 13.10/168 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Тус дүүрэгт 1 давхрыг өргөтгөн үйл ажиллагаа явуулж байгаа 599 иргэн, аж ахуйн нэгж байгууллага байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ 1 дүгээр хороонд 93 ➤ 2 дугаар хороонд 94 ➤ 3 дугаар хороонд 95 ➤ 4 дүгээр хороонд 216 ➤ 5 дугаар хороонд 52 ➤ 6 дугаар хороонд 49 аж ахуйн нэгж тус тус байна. 			
<p>Үүрэг даалгавар ТАВ: Барилгын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх, хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, стандартын шаардлага, машин тоног, төхөөрөмжийн аюулгүй байдалд хяналт тавих ажлаа эрчимжүүлэх. /Хотын стандарт хяналтын газар, Хот байгуулалт хөгжлийн газар Бусад чиг үүргийн байгууллагууд, Дүүргийн Засаг дарга нар/</p>				
	<p>Дүүргийн хэмжээнд иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд барилгын ажлын гаднах талбайн орчны аюулгүй байдлыг хангуулах ажлын хүрээнд барилгын ажил явагдаж буй 6 байршилд хашаа засварлах, орчны бохирдлыг арилгуулах, том оврын ачааны машин холдуулах, явган зам засварлах шаардлага хүргүүлэн зөрчлийг арилгуулан ажиллалаа.</p>			
<p>Үүрэг даалгавар ЗУРГАА: Нийтийн эзэмшлийн гудамж талбай, автобусны буудал, гудамж, талбайн хөшөө дурсгал, сандал, хүүхдийн тоглоомын талбай, авто замын гүүрэн гарц зэрэг байгууламжуудын өнгө үзэмжийг сэргээх ажлуудаа эрчимжүүлэх. /Захирагчийн ажлын алба Дүүргийн Засаг дарга нар, Хот тохижилтын газар/</p>				
	<p>Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК-тай хамтран 1-6 дугаар хороодын бичил цэцэрлэг, тоглоомын талбайн угаах, аюулгүй байдал хангах ажлууд хийгдэж дууссан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 12, 14, 17, 18, 19 дүгээр хороодын бичил цэцэрлэгийн засварын ажлуудыг газар дээр очиж зураг төсвийг зөвшилцөн ажлыг эхлүүлсэн. Дүүргийн хэмжээн дэх усан оргилуурын тоо бүртгэл, одоогийн байгаа нөхцөл байдлын талаарх</p>			

	судалгааг гарган засварлах шаардлагатай байршлуудыг жагсаалтыг Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.			
Үүрэг даалгавар ДОЛОО: Нийслэлийн Мэргэжлийн хяналтын чиг үүрэг шилжсэнтэй холбогдуулан эрүүл, ахуй, хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлын чанар, стандартад онцгой анхаарч, хяналт тавьж ажиллах. /Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Мал эмнэлгийн газар, Дүүргийн Засаг дарга нар/				
	<p>НХХ Дүүргийн 138, 139, 140, 145, 149 дүгээр сургуулиуд цахим дэлгүүрээс мах болон ногоогоо худалдан авч сурагчдын үдийн хоолыг хийж байна. Мөн БЕГ-аас сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний цахим систем нэвтрүүлэх сургалт уулзалтад 138, 139, 140, 145, 149 дүгээр сургуулиуд, СӨБ-ын 37, 102, 247 дугаар цэцэрлэгийн эрхлэгч нар тус цахим системийн танилцуулгад хамрагдан мэдээлэл авсан. Цахим системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>ХХҮХ Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн “Нөөцийн махны борлуулалтад хяналт тавих ажлын удирдамж”-ын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, НМЭГ, НХХААГ-тай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн мах худалдан борлуулж байгаа нийт 38 хүнсний дэлгүүрт хүнсний аюулгүй байдал, стандартын хэрэгжилтэд хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан ажиллаж байна.</p>			
Үүрэг даалгавар НАЙМ: ТҮЦ-ны асуудлуудыг шуурхай шийдвэрлэж, дараагийн шуурхай зөвлөгөөн дээр нөхцөл байдлыг танилцуулах. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар/				
	<p>Дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Газар албадан чөлөөлөх тухай” А/06 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Мөнгөн завьяа дэлгүүрийн автобусны буудал дээр байршуулсан нийт 6 түргэн үйлчилгээний цэгийг албадан нүүлгэж, газар чөлөөлөлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Газар албадан чөлөөлөх тухай” А/29 дүгээр захирамж батлагдсан. Тус захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбай, автобусны буудал дээр олноор байршуулсан зөвшөөрөлгүй түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлтийн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай төлөвлөгөө, судалгааг гарган бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>			
Үүрэг даалгавар ЕС: Түр худалдаа үйлчилгээ эрхлэх байршлын асуудлыг шуурхайлж, дүүргүүдийг мэдээллээр хангаж, ажлаа уялдуулан хамтран ажиллах. /Хот байгуулалт, хөгжлийн газар, Дүүргийн Засаг дарга нар/				
	Дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай, түр, сүүдрэвчтэй худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн хүсэлтийг авч дүүргийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа үйлчилгээг зохицуулах Зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэж, байршлыг тогтоож батлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			

Үүрэг даалгавар АРАВ: Дүүргүүдэд шилжүүлсэн “Хүүхдийн автобус”-нуудыг үйлчилгээнд нь шуурхай гаргаж, автобусны ашиглалт, техникийн шаардлага, стандартыг онцгой анхаарч, хүүхдүүдийг автобусаар тав тухтай, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах. Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Боловсролын газар, Дүүргийн Засаг дарга нар/

	<p>СТСХ Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд Dongfeng EQ6100STT6D1 маркийн нийт 2,151,333,331 төгрөгийн өртөг бүхий 7 ширхэг хүүхдийн автобусыг ЗДТГ-ын даргын 2023 оны А/68 дугаар тушаалаар ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэн авсан. БХ “Сургуулийн автобус” төслийн хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 37, 49, 72, 117, 140, 149-р сургуулийн автобус 6 чиглэлд давхардсан тоогоор 2490 хүүхдүүдийг тав тухтай, аюулгүй тээвэрлэж байна.</p>			
--	--	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ЭНХГЭРЭЛ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ

